

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 31

Номгон

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>Зорилт-1 Төрийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт, уялдаа холбоог сайруулах</b>							
1.1	Аймгийн "Удирдах ажилтан"-ы зөвлөгөөнийг зохион байгуулах, төрийн байгууллагын үр дүнг дүгнэх	Байгууллагын төсөв	Төрийн байгууллагын дундаж үнэлгээ	67	68	Аймгийн "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнд аймгийн удирдлагууд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагийн дарга, Төрийн болон орон нутгийн өмчит 9 байгууллагын дарга, 20 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Нарийн бичгийн дарга, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын дарга нар сумын нийт төсөвт байгууллагын дарга, нийт 256 удирдах албан хаагч оролцсон. Зөвлөгөөний үеэр нутгийн захиргааны байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн дүнг танилцуулж, 2025 онд хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө баталсан. Төрийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны дундаж үнэлгээ 73.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100
1.2	Байгууллагын удирдлагуудыг шуурхай цаг үеийн мэдээллээр хангах	-	Зохион байгуулсан хурлын тоо	18	20	Байгууллагуудын удирдах ажилтнуудыг цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын А/313 дугаар захирамжаар "Удирдах ажилтнуудын мэдээллийн цаг зохион байгуулах журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулан мөрдөж байна. Журмын дагуу 2025 онд аймгийн "Удирдах ажилтны мэдээллийн цаг"-ийг 16 удаа зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг албажуулсан, үүрэг даалгаврыг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд оруулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хурал зохион байгуулах журам шинэчлэгдсэн, Бүх ард түмний зуны XVI спартакиад, Архив, албан хэрэг хөтлөлт,	100

1	2	3	4	5	6	7	8
						төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг зэрэг цаг үеийн шинжтэй томоохон арга хэмжээнүүдээс шалтгаалан зорилтот түвшинд хүрээгүй болно.	
1.3	Аймгийн "Хөдөлмөрийн аварга" шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах	Байгууллагын төсөв	Бэлтгэл ажлын гүйцэтгэлийн хувь Шагнагдсан иргэдийн тоо	100 10	100 10	Аймгийн Засаг даргын 2022 оны А/764 дүгээр захирамжаар батлагдсан "Хөдөлмөрийн аварга шалгаруулах журам"-ын дагуу аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, тухайн салбар, байгууллагын үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр, ажлын үр дүнгийн үзүүлэлтийг харгалзан бодлогын хэлтсүүдээс шалгаруулан ирүүлсэн 19 салбарын 24 иргэний материалыг "Удирдлагын баг"-аар хэлэлцэн, 20 иргэнийг "Аймгийн Хөдөлмөрийн аварга"-аар шалгаруулан, шагнал гардуулах үйл ажиллагааг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Усан бассейн спорт цогцолборт ёслол төгөлдөр зохион байгуулсан.	100
<b>Зорилт-2 Орон нутгийн гадаад бодлогыг эрчимжүүлэх</b>							
2.1	Гадна орны хот мужуудтай соёл, боловсрол, хөдөө аж ахуй, байгаль орчин, худалдаа, эдийн засаг зэрэг салбарт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх	Жилийн хөгжлийн төлөвлөгөө ө 70.0 сая төгрөг	Уулзалт хэлэлцээрийн тоо	6	8	Тайлант онд гадаадын зочид төлөөлөгчдийг угтах авах, үдэх ажлын хүрээнд нийт 5 удаагийн айлчлалаар 22 гадны зочид төлөөлөгчдийг хүлээн авч, уулзалт, хэлэлцээр болон холбогдох арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1.Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, НҮБ-ийн Монгол дахь суурин төлөөлөгч, Европын холбооны суурин төлөөлөгч нарын Баянхонгор аймагт 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хийсэн албан айлчлал, хүндэтгэлийн хүлээн авалт 2.Бүгд найрамдах Польш улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, ноён Кшыштоф Бойко 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Баянхонгор аймагт албан ёсны уулзалт 3.БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Минжуань 2025 оны 07 дугаар сарын 22-нд Баянхонгор аймагт айлчлал 4.Баянхонгор аймагт 100 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг бэлэглэх тухай Баянхонгор аймаг болон Арабын Нэгдсэн Эмират улс хоорондын санамж бичгийн хүрээнд АНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мухаммед Аль-Гуртаси Аль-Нуайми тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр Баянхонгор аймагт албан айлчлал хийсэн. Элчин сайдыг хүлээн авах, үдэх арга хэмжээ	100

1	2	3	4	5	6	7	8
						5.ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Алексей Николаевич Евсиков 2025 оны 09 дүгээр сарын 18-нд Баянхонгор аймагт айлчлал зэрэг болно.	
2.2	Хамтын ажиллагаатай улс орнуудтай олон талт уулзалт зохион байгуулж, сайн туршлагыг орон нутагт нэвтрүүлэх	-	Уулзалт хэлэлцээрийн тоо, Санамж бичиг, гэрээний хэрэгжилтийн хувь	40	670	<p>Баянхонгор аймаг БНХАУ, ОХУ, АНЭУ, БНСУ, БНПУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдуудтай уулзаж боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарт дараах ажлыг хийж гүйцэтгэхээр хэлэлцэн тохиролцлоо. Үүнд:</p> <p><b>Боловсролын салбарт:</b></p> <p>1.БНХАУ-ын Гансу мужийн Ланжоу, Хөх нуур мужийн Шининг хотуудад “Монгол Улсын цөлжилттэй тэмцэх ногоон хөгжлийн семинар”-т 5 төрийн албан хаагч, Хөх хот, Ордос, Бугот зэрэг хотуудад “Монгол Улсын хүлэмжийн ногоо тариалах технологийн сургалт”-д 5 төрийн албан хаагч сурсан.</p> <p>2.БНХАУ-ын Ниншя Хотон Үндэстний Өөртөө засах орны Яргай хот, Жүнвэй хот болон Үжун хотуудад “Монгол Улсын Ус хөрсний хамгаалалт, цөлжилттэй тэмцэх семинар”-т 3 төрийн албан хаагч хамрагдсан.</p> <p>3.БНХАУ-ын Ланжоугийн их сургуульд 2025 онд 5 оюутан суралцаж сургалтын төлбөрийн 30 хувь болох 12,120,000 төгрөгийг аймаг, орон нутгаас хариуцан ажиллав.</p> <p>4.БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймагт уламжлалт анагаах ухааны чиглэлээр 2026 онд 3 эмчийг мэргэшил дээшлүүлж сургахаар тохиролцсон.</p> <p>5. АНЭУ-ын элчин сайд Гүнж Шейха Фатима бинт Мубаракийн нэрэмжит 100 хүүхдийн цэцэрлэгийг орон нутагт албан ёсоор хүлээлгэн өглөө.</p> <p><b>Эрүүл мэндийн салбарт:</b></p> <p>БНСУ-ын Кенги аймгийн Гал түймэртэй тэмцэх газраас хандивлаж буй яаралтай түргэн тусламжийн зориулалттай эмнэлгийн 2 автомашиныг албан ёсоор хүлээн авсан</p> <p><b>Соёлын салбарт:</b></p> <p>БНПУ-ын Элчин сайд холбогдох бүрэлдэхүүний хамт аймгийн ХДТ, хүүхдийн Тэмүжин театр, Биений тамир спортын газар, Түүх угсаатны зүйн музейн үйл ажиллагаатай тус тус танилцууллаа. Польшийн элчин сайдын яамны талаас “Сарны тасалбар” уран сайхны киног Баянхонгорчуудад үнэ төлбөргүй толилууллаа.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						Гэрээ, санамж бичгийн хэрэгжилт 70 хувьтай байна.	
<b>Зорилт 3. Байгууллагын албан хаагчдын ёс зүй, чадавхуйн зарчмыг төлөвшүүлж, сургалт хөгжил нийгмийн асуудлыг сайжруулах</b>							
3.1	Байгууллагын 2025 оны бүтэц орон тоог батлах, үйлчилгээн ий албанд шинээр томилогдсон албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулах хянах	-	Батлагдсан бүтэц орон тоо, шинээр байгуулсан хөдөлмөрийн гэрээний тоо	95 9	103 15	Засгийн газрын "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай" 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 37 дугаар тогтоолтой уялдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/08 дугаар тушаалаар үндсэн 56, гэрээт 45, нийт 101 орон тоотойгоор батлуулсан. Төрийн үйлчилгээний 33 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан.	100
3.2	Аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын сургалт нийгмийн баталгааг хангах стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг хангах	Жилийн хөгжлийн төлөвлөгөө 10.0 сая төгрөг	Хөтөлбөр батлуулсан байх, хэрэгжилтийн хувь	0	100	Аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын сургалт нийгмийн баталгааг хангах стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/53 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг суурь судалгаанууд хийж, боловсруулах шатандаа явж байна. Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2025 онд Удирдлагын академийн богино дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад 3 алба хаагч, салбар, чиг үүргийн богино хугацааны сургалтад 22 албан хаагч тус тус хамрагдсан байна.	30
3.3	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Жилийн хөгжлийн төлөвлөгөө 1.3 сая төгрөг	Хэрэгжилтийн хувь	50	100	Аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороо нь 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр үйл ажиллагааны төлөвлөгөө болон Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, орон нутгийн төсвөөс 4.0 сая төгрөг шийдвэрлүүлэн, зарцуулж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан. Хяналт шинжилгээ үнэлгээгээр 20 сум, Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгээр 20 сум, 190 байгууллагын ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан.	100
3.4	Байгууллагын албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж,	-	Хэрэгжилтийн хувь	0	100	Байгууллагын албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний хүрээнд 22 албан хаагчийг мэргэшүүлэх	100

1	2	3	4	5	6	7	8
	төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх					сургалтад хамруулж, бүх албан хаагчдыг салбар, бүс, улсын чанартай сургалт, семинарт 1-2 удаа оролцуулсан байна.	
3.5	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	34	70	Байгууллагын албан хаагчдын 2025 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний хүрээнд хийгдсэнз томоохо ажлуудаас дурдвал: 1.Гэрт амьдардаг 4 өрхийг халаалт, дулаалгын chip багцад хамруулсан. 2.Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан, 18 албан хаагчийг "Энхсаран" сувилалд хамруулсан. 3.Нийт албан хаагчдад ажилласан жил, зэрэг дэв, ур чадвар, орон нутгийн нэмэгдэл, хоолны үнийн хөнгөлөлт болон холбогдох бусад нөхөн төлбөрийг хууль, тогтоомжийн дагуу бүрэн олгож ажилласан.	100
3.6	Төрийн албан хаагчдын ёс зүйг сайжруулахад сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх	Байгууллагын төсөв	Албан хаагчдын тоо	0	100	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөнд тусгагдсны дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"г сурталчлах 30 удаагийн сургалтыг зохион байгуулж, 1312 төрийн албан хаагчийг хамруулж ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Хөх өнгийн дэвсгэр бүхий тээврийн хэрэгсэл"-ийг төрийн албан хэрэгцээнд ашиглахыг уриалсан контентыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан 11000 хүний хандалтыг тус тус авсан байна.	100
3.7	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын албан хаагчдын дунд ёс зүйн мэдлэг олгох "Дэвжээ" тэмцээн зохион байгуулах	Хөтөлбөрийн санхүүжилт 2.7 сая төгрөг	Төрийн байгууллагын тоо	02	44	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан удирдамжийн хүрээнд Дэвжээ тэмцээн зохион байгуулж, тэмцээнд Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Байгаль орчны газар, Нийгмийн даатгалын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Баянхонгор-Эрчим хүч ЦТ ХХК-ний ёс зүйн дэд хорооны гишүүд, албан хаагчдын төлөөллөөс бүрдсэн 10 баг	100

1	2	3	4	5	6	7	8
						оролцож, хурд хүч, авхаалж самбаа, оюун ухааны цар хүрээ, мэдрэмж, багийн ажиллагаагаар өрсөлдөж, Тэргүүн байранд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Дэд байранд Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар, Гутгаар байранд Байгаль орчны газар, Тусгай байранд Стандарт хэмжил зүйн хэлтэс, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар тус тус байр эзэлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагналаа.	
3.8	9001:2015 чанарын менежментийн тогтолцоо-шаардлага стандартыг хэрэгжүүлж, магадлах аудит хийлгэх	Байгууллагын төсөв	Стандартын хэрэгжилтийн хувь	89,8	90	Чанарын багийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлж ажилласан. Кю сертф ХХК-аар магадлах аудитыг хийлгэж, 2 жижиг үл тохирол, 2 сайжруулах асуудалтайгаар "Тэнцэнэ" үнэлгээ авсан. Илэрсэн 2 жижиг үл тохирлыг залруулсан.	100
3.9	Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	90	100	Байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 18 заалт бүхий арга хэмжээ тусган боловсруулж, 94 хувьтай хэрэгжүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 96 албан хаагчыг АШУУИС-ийн дэргэдэх Япон Монголын хамтарсан эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт 98 хувьтай хамруулсан. "Бие сэтгэлийн учиг" төрийн бус байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлт нэгтгэл, шинжилгээний үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийлгэж, сувилуулах шаардлагатай 18 албан хаагчыг Энх саран сувилалд амрааж, сэргээн засах эмчилгээ үйлчилгээнд хамруулсан. Дотоод шүүрэл, бодисын солилцооны эмгэг, эрүүл хооллох хэв маяг, стресс бухимдлаа тайлах сэдвүүдээр эрүүл мэндийн сургалтад байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулж, мэдлэг олгосон. Албан хаагчдын сэтгэл зүйн байдал, стресст өртөж байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлох судалгаа хийлгэж, ажилтан албан хаагчдад танилцуулсан. Фитнесс, иог, бүжгийн спортоор хичээллэх чиглэлээр ажилтнуудаас бүрдсэн 3 анги үүсгэн спорт, эрүүл мэнд, цэнгээнт бүжгийн клубүүдтэй хамтран ажилласан. Ажилтан албан хаагчдын дунд 9 төрөлт тэмцээн уралдааныг батлагдсан удирдамжийн дагуу амжилттай зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо болон	100

1	2	3	4	5	6	7	8
						эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд байгууллагын төсвөөс нийтдээ 31.5 сая төгрөг зарцуулсан.	
<b>Зорилт 4.Бодлогын баримт бичгийн төлөвлөх, тайлагнах, хяналт тавих, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж орон нутгийн бодлогын алдаа дутагдлыг засаж сайжруулалт хийх</b>							
4.1	Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	-	Гүйцэтгэлийн хувь	0	100	Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу боловсруулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн IX хуралдааны 9/58 дугаар тогтоолоор батлуулсан.	100
4.2	Төрийн байгууллагуудын төрөөс баримтлах бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, тайлагналт, хяналтыг сайжруулах	-	Байгууллагуудын үнэлгээ	67	68	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар удирдамжийн дагуу 20 сум, 55 байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд, аймгийн Засаг даргын 2025 оны 66 дугаар удирдамжийн дагуу хангайн 5, говийн 5 сумдын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэж, бодлого төлөвлөлт тайлагналтад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Заг, Баянлиг, Баян-Овоо сумдын Төрийн албан хаагчдын зөвлөгөөн, нийгмийн салбарын болон боловсролын салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнд тус тус "Бодлого төлөвлөлт, гүйцэтгэл", "Тайлагналтын арга зүй" сэдвээр сургалт мэдээлэл хийсэн. Зөвлөгөөн мэдээлэлд 410 албан хаагч хамрагдсан. Бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чадавхжуулах сургалтыг орон нутгийн хөгжлийн төв Баянхонгор, Богд, Баянцагаан, Бууцагаан, Жаргалант сумдад 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд бүсчлэн 20 сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудад зохион байгуулсан. Мөн аймгийн Засаг даргын харьяа агентлаг, төсөвт 8 байгууллагын захиалгаар 210 албан хаагчид бодлого төлөвлөлт, тайлагналтын сургалт хийсэн.	100
4.3	Тамгын газрын бодлогын хэлтсүүдийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хэлтсийн тоо	7	7	Баянхонгор аймгийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нэгдсэн тайланг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, зөвлөмжийг 7 хэлтэс тус бүрт хүргүүлсэн. Хэлтсүүдийн 2024 оны жилийн эцсийн	100

1	2	3	4	5	6	7	8
						дундаж үнэлгээ 85.7 хувь байгаа нь 2023 оны жилийн эцсээс 1.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2025 оны жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн үнэлгээ гарах хугацаа болоогүй.	
4.4	Сумдын Засаг даргын Тамгын газар, агентлаг, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Байгуул агын төсөв	Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан сум, байгууллагын тоо	53	53	Сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 24 агентлагт, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 11 байгууллагад, нийт 55 байгууллагад хүргүүлсэн. Сумдын Засаг даргын Тамгын газар, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, бодлогын хэлтсүүд нийт 60 байгууллагад илтгэх хуудас зөвлөмжийг хүргүүлсэн.	100
<b>Зорилт -5.Төрийн байгууллагын ил тод байдлыг сайжруулах</b>							
5.1	Төрийн байгууллагын ил тод байдлын үнэлгээг өсгөх	-	Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" нэгдсэн системийн үнэлгээний дундаж хувиар	57	80	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, сумдын ЗДТГ-т шилэн индексийн 2024 оны жилийн эцсийн тайланг 36 байгууллага, 70.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнаж байсан бол 2025 оны гуравдугаар улирлын тайланг 11 сум, 18 байгууллага, нийт 29 байгууллага 62.68 хувьтай тайлагнасан байна. Тайлант оны дөрөвдүгээр улирлын шилэн индексийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс тасалбар болгон хүлээн авсан, үнэлгээ хийгдээгүй байна.	26
5.2	Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудасны ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх, хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	-	Төрийн байгууллагын "gov.mn" цахим хуудсыг ашиглаж байгаа төрийн байгууллагын тоо	0	150 дээш	Төрийн нэгдсэн "gov.mn" цахим хуудсыг аймгийн төрийн байгууллагуудад нэвтрүүлэх ажлын хүрээнд 20 сумын Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Авто тээврийн төв, Баянцагаан сумын төсөвт байгууллагууд зэрэг 27 байгууллагын холбогдох албан хаагчдад админ эрх үүсгэж, системд нэвтрэх эрх олгосон. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан сургалтад хамрагдсан.	18

1	2	3	4	5	6	7	8
5.3	Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийг сум, багт шинээр байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх	-	Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн тоо	8	11	Е-Mongolia операторын үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний тоог тогтмол нэмэгдүүлэх ажлын хүрээнд төрийн үйлчилгээний нэгдсэн төв дэх "ХУРДАН" төв, нэгдсэн эмнэлэг дэх "ХУРДАН" цэг, Баруун бүсийн худалдааны төвийн "ХУРДАН" цэг болон сумдын "ХУРДАН" цэгүүдээр дамжуулан 87 байгууллагын 1286 төрлийн үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй 46,000 гаруй иргэдэд үзүүлсэн байна.	100
5.4	Засаг даргын дэргэдэх ХУРДАН клубийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах	-	Арга хэмжээ, сургалтын тоо	1	2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх ХУРДАН клубийн 30 гишүүнийг сургагч багшаар бэлтгэн, "Цахим орчны зохистой хэрэглээ", "Цахим үе тэнгийн дээрэлхэлт" 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. ХУРДАН клубийн сургагч багш нар 6 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 340 хүүхдийг хамруулсан байна.	100
<b>Зорилт-6 Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж ирсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж, улирал бүрийн мэдээг үнэн зөв тайлагнаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах</b>							
6.1	Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх, e-office-т бүртгэх, дээд шатны байгууллагад тайлагнах	-	Өргөдөл гомдлын тоо	3242	3000	Аймгийн нийт төрийн байгууллага албан тушаалтанд 2025 онд ирүүлсэн 2206 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг нэгтгэн, мэдээ тайланг I, II, III, IV улирлын байдлаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 89.6 хувьтай байна. Өргөдөл гомдлын 2025 оны IV улирлын мэдээ, тайланг 12 дугаар сарын 31-ний байдлаар тасалбар болгон гаргана. Аймгийн 2025 оны өргөдөл гомдлын тоог 2018-2024 оны өргөдөл гомдлын тоонд харьцуулахад 1.5-5 дахин буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/489 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлж байгууллагын дотоод асуудал, хөдөлмөрийн харилцаатай холбоотой санал хүсэлт, үйлчилгээ авах хүсэлт зэргийг нийт өргөдөл гомдлын тоонд оруулахгүй байгаатай холбоотой байна.	100

1	2	3	4	5	6	7	8
6.2	11-11 төвд ирж байгаа иргэдийн гомдлыг шуурхай шийдвэрлэх	-	Өргөдөл гомдлын тоо	103	90	Аймгийн Засаг даргын Тамгын газарт 2025 онд Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин ирүүлсэн 118 өргөдлийг хүлээн авч, хуулийн дагуу шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллалаа. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 95 хувьтай, хугацаа болоогүй 6 байна.	100
<b>Зорилт-7 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, захиргааны хэм хэмжээг тогтоосон шийдвэрийг хянах, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах , хяналт тавих</b>							
7.1	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн зардал 3.0 сая төгрөг	Хэрэгжилтийн хувь	100	100	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргын 2025 оны А/32 дугаар захирамжаар 5 зорилго, 9 зорилт 17 арга хэмжээ төлөвлөн батлуулж 100 хувьтай хэрэгжилтийг ханган төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн биелсэн.	100
7.2	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах	-	Хяналт шалгалтын тоо	37	37	Салбарын хяналтын газраас баталсан удирдамжийн дагуу Авто зам тээвэр-18, Эрчим хүчний-10, Геологи уул уурхай, газрын тос хийн хяналт-10, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр 15, нийт 53 удаагийн төлөвлөгөөт шалгалтыг 68 объектод гүйцэтгэсэн. Шалгалтын явцад илэрсэн дутагдлыг арилгуулахаар 29 аж ахуйн нэгжид албан шаардлага хүргүүлж, 11 хуулийн этгээд, 4 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан-18, татгалзсан-3 зөрчил шалган шийдвэрлэж 60.300.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авч зөрчлийг арилгуулсан.	100
7.3	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн санхүүж илт 3.0 сая төгрөг	Хэрэгжилтийн хувь	100	100	Аймгийн Засаг даргын 2025 оны А/98 дугаар захирамжаар 3 зорилт 12 арга хэмжээг батлуулан 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлснээр зорилтот бүлгийн 2073, нийт 7463 иргэдийн эрх зүйн мэдлэг ойлголт дээшилсэн ба сургалтын дараах асуулгаар хүний эрхийн мэдлэг ойлголт 35 хувиар нэмэгдсэн байна. Мөн залилах гэмт хэрэг 5 нэгжээр буюу 38 хувиар буурсан байна.	100
7.4	Хууль тогтоомжийг сурталчлах, хянан шалгах, зөвлөн туслах ажлыг сумдад зохион байгуулах	-	Сумын тоо Хэрэгжилтийн хувь	0 30	3 80	Хууль тогтоомжийг сурталчлах төрийн байгууллага аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах ажлыг 04 дүгээр сарын 29-нөөс 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд 10 байгууллагын төлөөлөл болсон албан хаагчид Хүрээмарал, Баянбулаг, Бууцагаан, Бөмбөгөр сумдын төрийн албан хаагч, иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 7-12 дугаар ангийн сурагчдаас бүрдсэн нийт 928	100

1	2	3	4	5	6	7	8
						хүнд сургалт нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж сумдын Засаг дарга нарт 4 удаа зөвлөмж хүргүүлж ажилласнаар эрх зүйн ажлын хэрэгжилт сайжирч 2 сумын гэмт хэрэг буурсан байна.	
7.5	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн санхүүжилт 2.0 сая төгрөг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум 62 байгууллагад 24 удаагийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтыг 89 сэдвээр, 40 удаагийн захиалгат сургалтыг 53 сэдвээр, 63 удаагийн цахим, танхимын сургалтыг 63 сэдвээр, 4087 төрийн албан хаагч, 1303 иргэд, 2073 зорилтот бүлэгт зохион байгуулж ажилласан. Дотоод нөөц бололцоонд тулгуурлан сум, байгууллагуудын 60 эрх зүйн хөтчийг танхим болон цахим хэлбэрээр 12 сэдвийн хүрээнд чадавхжуулах, давтан сургах сургалтад хамруулан ажилласан. Аймгийн хэмжээнд Хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг 155 иргэд, төрийн албан хаагчдад өгч, 16 төрлийн 2880 ширхэг гарын авлагыг түгээж, 471 төрийн албан хаагчийг "Бид ёс зүйтэй төрийн албан хаагчид", "Авлигын эсрэг нэгдье", Иргэдийн дунд "Ирээдүйнхээ төлөө нэгдье", "Авлигын эсрэг гэрэл түгээе" зэрэг чөллэнж, нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь	100
7.6	Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж Засаг даргын нарын нийтлэг хэм хэмжээ тогтоосон актыг зохих журмын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Хэм хэмжээний актын тоо	0	2	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй аймгийн Засаг даргын 2 шийдвэрт хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулж, батлуулах талаар холбогдох нэгж, байгууллагын 70 гаруй албан хаагчдад сургалт хийсэн. Аймгийн ИТХ-аар 1 хэм хэмжээний акт батлуулж, ХЗДХЯ-д хүргүүлэн, дахин хянуулах талаар дүгнэлт ирүүлсэн. Аймгийн Засаг дарга, Цагдаагийн газрын даргын хамтарсан 2025 оны А/359/85 дүгээр захирамж, тушаалаар "Золбин нохой, муурыг хот, суурин газарт галт зэвсэг ашиглан устгахад мөрдөн ажиллах журам"-ыг батлуулж ХЗДХЯ-д хянуулан захиргааны хэм хэмжээний актын 7294 дугаарт бүртгүүлж, холбогдох сум, байгууллагуудад хүргүүлсэн.	100

1	2	3	4	5	6	7	8
<b>Зорилт-8 Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангуулах, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх</b>							
8.1	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлыг хангах	-	Бэлтгэл ажлын гүйцэтгэлийн хувь	50	100	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/47 дугаар тушаалаар үзлэгт бэлтгэх, зохион байгуулах ажлын хэсэг томилогдон төлөвлөгөө гаргаж, бэлтгэлийг бүрэн хангаж ажилласны үр дүнд албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа 1000 онооноос 947 оноо буюу 94.7 хувь, архивын үйл ажиллагаа 1000 онооноос 987 буюу 98.7 хувь, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт 100 онооноос 91.9 оноо буюу 91.9 хувиар, ерөнхий үнэлгээ 96.4 хувь буюу бүрэн хангалттай үнэлэгдсэн.	100
8.2	"ERP" E-office нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулах	-	Систем ашиглалтын хувь	50	80	Аймгийн хэмжээнд epr.e-mongolia.mn байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ашиглалтыг нэмэгдүүлж, нийт 200 байгууллагын 5153 албан хаагч бүртгэсэн байна. Мөн 2025 онд цаг бүртгэлийн систем, албан бичиг солилцооны Досх дундын систем ашиглалтыг нэмэгдүүлж 98 хувийн хэрэгжилттэй байна. Тайлант онд байгууллагын хэмжээнд epr системээр ирүүлсэн нийт 6657 албан бичиг хүлээн авч шийдвэрлэн, нийт 2686 албан бичгийг төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны системээр дамжуулан ажилласан байна. ERP системээр ирсэн бичгийн 72 хувь, явуулсан бичгийн 74 хувийг бүртгэн шилжүүлсэн байна. Байгууллагын бичиг төлөвлөлт, хяналтын И-Оффис системд 2025 онд 2002 бичиг бүртгэгдсэний 425 идэвхтэй, 824 илгээсэн, 749 эцэслэн хаасан, 4 бичгийг дарга татгалзсан төлөвтэй байна. Энэ нь аймгийн Засаг даргын Тамгын газраас 2025 онд гарсан 783 захирамж, 222 тушаал, 2686 албан бичиг, нийт 3691 бичгийн 54.1 хувийг системд оруулсан үр дүнтэй байна.	55
8.3	Байгууллагын 2022 оны байнга хадгалах хадгаламжийн нэгжийг Төрийн архивын цахим санд шилжүүлэх	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Байгууллагын архивын 2021 оны 283 хадгаламжийн нэгжийг цахим сан үүсгэн Төрийн архивд шилжүүлсэн. Байнга хадгалах 2022 оны 260 хадгаламжийн нэгжийг цахимд шилжүүлэх бэлтгэл ажил хийгдэж төрийн архивын хэлтэст хянуулахаар хүлээгдэж байна.	0

1	2	3	4	5	6	7	8
8.4	Үндэсний төрийн архивын цахимжуулалтын шинэ систем cams.e-archives.gov.mn-нд шилжсэн 200-гаас дээш хөмрөгийн дата баазийг шинэчлэн батлагдсан журмын дагуу хянах, тулгах, засах	Байгууллагын төсөв /Шаардлагатай үед /	200-гаас дээш хөмрөгийн дата баазыг шинэчилсэн байх	0	100	Төрийн архивын сан хөмрөг, цахим санг cams.e-archives.gov.mn шинэ системд 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс шилжиж байгаатай холбогдуулан "Сан хөмрөгийн нэгдсэн жагсаалт"-ыг аймгийн Засаг даргын 2025 оны А/226 дугаар захирамжаар батлуулж Төрийн архив болон сан үүсгэгч байгууллагын ажилтнууд нийт 158 хөмрөгийн 158 данс, бүртгэл 9555 хадгаламжийн нэгж бүхий 171825 хуудас мэдээллийн 441973 өгөгдөл оруулж ажилласнаар дээрх баримтуудыг ашиглалтаас чөлөөлж, лавлагаа мэдээллийг онлайнаар хайх боломжийг бүрдүүлээ.	100
8.5	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг Монгол үндэсний бичигт шилжих ажлыг зохион байгуулж, хяналт тавих	Хөтөлбөр бодлого чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 3.0 сая төгрөг	Бүрэн шилжсэн байх	0	100	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг Монгол үндэсний бичигт шилжүүлж байгаатай холбогдуулан Үндэсний бичгийн хэвлэмэл хуудасны эх бэлтгэх хянуулах, ажилтныг сургах, хэвлэгч машин нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч ажилласан. Түүнчлэн аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ны А/250 дугаар захирамжаар Төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын архив, бичиг хэргийн 180 байгууллагын 200 ажилтныг 2025 оны 06 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд Үндэсний уйгуржин монгол бичгийн сургалт, дадлага ажлыг хамруулан зохион байгуулж цай, багш нарын цалингийн зардалд 3 сая төгрөг зарцуулсан.	100
8.6	Архивын баримтын тодорхой хэсгийн тоо бүртгэл ирцийн програмд хамруулах	Жилийн хөгжлийн төлөвлөгөө 15.0 сая төгрөг	Баримтыг тодорхой хувийг хамруулсан байна.	0	100	Төрийн архивын сан хөмрөгийн баримтыг ирц тоо бүртгэлийн программд шилжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын 2025 оны А/172 дугаар захирамжаар 15.0 сая/төг зарцуулахаар шийдвэрлүүлэн үнийн болон жишиг судалгаа хийж сонгогдсон аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, цалин хөлсний 4 дүгээр сангийн нийт 5158 баримтыг тоо бүртгэлийн системд шилжүүлэх ажлыг зохион байгуулан аймгийн Засаг даргын 2025 оны А/608 дугаар захирамжаар хүлээн авч, ашиглаж эхэлснээр ирц, хөдөлгөөнийг автомат системээр бүртгэх боломжийг бүрдүүлж ажиллалаа.	100
8.7	Төрийн болон байгууллагын архивын баримтын	Архивын ерөнхий	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	88	100	"Төрийн болон байгууллагын архивын баримтын цахимжуулалтад 2025-2029 онуудад баримтлах бодлого, чиглэл"-ийг аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын	100

1	2	3	4	5	6	7	8
	цахимжуулалтын талаарх 2025-2028 оны аймгийн бодлого чиглэл, батлуулах, төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах	газар, Байгууллагын цалингийн саны сан 155.0 сая төгрөг				24-ний өдрийн А/157 дугаар захирамжаар, "Төрийн болон байгууллагын архивын баримтын цахимжуулалтад 2025-2029 онуудад баримтлах бодлого, чиглэл"-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/161 дүгээр захирамжаар тус тус батлуулж дараах ажлыг хийж хэрэгжүүллээ. Үүнд: 1.Төрийн архивын цахим сангийн нийт ажилтнууд 24 хөмрөгийн 1091 хадгаламжийн нэгжийн 76264 хуудас баримтыг цахим хувь үүсгэсэн. 2.Сан үүсгэгч 167 байгууллагын архив, албан хэрэг хөтлөгч ажилтнууд нь үндсэн 2022, нэмэлт 2018-2021 онуудын 10092 хадгаламжийн нэгжийн 182699 хуудас баримтыг 431374 өгөгдөл бүхий цахим хувь үүсгэн санд шилжүүлж, дуудалтанд бэлтгэн, цаасан баримтыг ашиглалтаас чөлөөлж ажилласан. 3.Байгууллагуудын удирдлагын 2022 оны баримтыг цахимаар болон цаасан хэлбэрээр хүлээн авах ажилд цахим баримтыг хард дискт хуулах үүргийн дагуу оролцож төрийн болон хувийн 164 байгууллагын 19,741 хадгаламжийн нэгжийн 354,188 хуудастай 261 gb багтаамжтай цахим баримтыг хард дискт хуулж бүртгэлжүүлэн сан хөмрөгт шилжүүлсэн.	
8.8	"Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх 2025-2028 оны бодлого, чиглэл" батлуулах, төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах	Хөтөлбөр бодлого чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 2.0 сая төгрөг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80	100	"Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх 2025-2028 оны бодлого, чиглэл"-ийг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны А/18 дугаар захирамжаар, тус бодлого чиглэлийг 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны А/265 дугаар захирамжаар тус тус батлуулж дараах ажлыг хийж хэрэгжүүллээ. Үүнд: 1.Санхүү эдийн засгийн их сургуулийн Нийгмийн шинжлэх ухааны дээд сургуультай Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй ажилтан орон нутагт бэлтгэхээр санамж бичиг байгууллаа. Санамж бичгийн хүрээнд магистрын 17, бакалаврын 23 ажилтныг элсүүлэх ажлыг зохион байгуулан хичээлийг эхлүүллээ. Мөн Түүхч, архивч мэргэжлээр орон нутгийн болон өдрийн ангид суралцаж байсан 8 ажилтан бакалаврын зэрэгтэй төгсөж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>2.Төрийн болон төрийн өмчит аж ахуй нэгж, байгууллагын архив, бичиг хэргийн 180 байгууллагын 200 ажилтныг 6, 11 дүгээр саруудад 2 удаа үндэсний монгол бичгийн сургалтад хамруулан, Үндэсний хэлний бодлогын зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу <a href="http://www.monscript.mn">www.monscript.mn</a> хөрвүүлэгчийг нэгдсэн журмаар ашиглаж эхэлснээр зөв бичих дүрмийн алдаа болон ажлын ачааллыг 10 хувиар буурууллаа.</p> <p>3.Архивын ерөнхий газрын сургалтын төвд 12 ажилтан мэргэшүүлэх, 5 ажилтан мэргэжил олгох сургалтад хамрагдлаа.</p> <p>4.Баянхонгор аймгийн Архивын хэлтэс архив, албан хэрэг хөтлөлтийн захиалгат сургалтыг 17 удаа 1060 ажилтанд, Мал эмнэлгийн газрын салбарын 110, Санхүүгийн албаны дарга мэргэжилтнүүдийн 48, Ураг удам судлах аймаг сумдын ажлын хэсгийн 88, нийт 401 ажилтан хамруулж, зөвлөмж, үүрэг, чиглэл өгч ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь</p>	
8.9	Төрийн архивын баримтыг цахим санд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор "Иж бүрэн нягтлан шалгах" 2024-2028 оны бодлого, чиглэлийн 2025 оны төлөвлөгөө батлуулах, хэрэгжүүлэн ажиллах.	Хөтөлбөр бодлого чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээн зардал 2.0 сая төгрөг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	88	100	"Төрийн архивын баримтыг Иж бүрэн нягтлан шалгах бодлого, чиглэл"-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/13 дугаар захирамжаар батлуулж төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 12 хөмрөгийн 190 хадгаламжийн нэгжийн 13013 хуудас баримтыг иж бүрэн нягтлан шалгаж, тоо бүртгэлд хамруулан, цахим хувь үүсгэн, БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн санд шилжүүлснээр лавлагаа мэдээлэлд ашиглах, цахим системд холбох боломжийг бүрдүүлээ. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь .	100
8.10	Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах 2023-2027 оны төлөвлөгөө батлуулах,	Байгууллагын төсөв /шаардлагатай үед/	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	60	100	"Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого чиглэл"-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын 2025 оны А/10 дугаар захирамжаар батлуулан төлөвлөгөөг 100 хувьтай ханган ажиллалаа. Үүнд: 1.Төрийн архивын галын хийн систем, хяналтын нэгдсэн төвийг ашиглалтад оруулан аюулгүй байдлын үзүүлэлтийг 90 хувьд хүргэсэн.	100

1	2	3	4	5	6	7	8
	хэрэгжүүлэх ажиллах					<p>2.Архивын тасгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Онцгой байдлын газраас 3 удаа үзлэг шалгалт хийж, 12 ажил зохион байгуулсан.</p> <p>3.Сан хөмрөгт хүлээн авсан, иж бүрэн нягтлан шалгалт хийсэн нийт баримтыг хамгаалах хайрцгаар бүрэн хангасан.</p> <p>4.Архивын харуул хамгаалалтын ажилтнууд архивын байрны дээвэр, хаяавч, усны хаялганд 2 удаа урсгал засвар хийж ажилласнаар аюулгүй байдлыг 30 хувиар дээшлүүлсэн.</p>	
<b>Зорилт 9. "Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх"</b>							
9.1	Сумдын санхүүгийн алба, төсөвт байгууллагуудад ажлын байрны сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах	Байгууллагын төсөв	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн сумын тоо	19	19	<p>Аймгийн Засаг даргын Тамгын гарзын даргын 2025 оны 03 дугаар удирдамжийн дагуу 20 сумын Санхүүгийн албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/181 дүгээр захирамж, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 41 дүгээр удирдамжийн дагуу Бөмбөгөр, Бууцагаан, Баянбулаг, Хүрээмарал сумдад 09 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зөвлөн туслах, хяналт шалгалт хийх ажлыг хийж гүйцэтгэсэн</p>	100
9.2	Төсөвт байгууллагуудаас төсвийн төслийг хүлээн авч нэгтгэн боловсруулж 2026 оны төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлж, хянуулах	Байгууллагын төсөв	Зардлын төрөл зүйл тус бүрээр судалгааг хүлээн авч нэгтгэн батлуулсан байгууллагын тоо	168	168	<p>Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлого зарлагын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд судалгаа, бүртгэл таамаглал, тооцоололд үндэслэн 168 байгууллагаас хүлээн авч нэгтгэн боловсруулж Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу 2025 оны 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлж, төсвийн урсгал зардлыг 65,033,0 сая төгрөгөөр, төсвийн орлогыг 34,7 тэрбум төгрөгөөр хянуулсан.</p>	100
9.3	Улсын Их хурлаар батлагдсан төсөвт хуваарилалт хийж, аймгийн 2026 оны төсвийг сум байгууллага тус бүрээр боловсруулан хуулийн хугацаанд АИТХ-д	Байгууллагын төсөв	Аймгийн 2026 оны төсвийн тогтоолыг батлуулсан байгууллагын тоо	168	168	<p>Улсын Их Хурлаас Баянхонгор аймгийн 2026 оны төсвийн суурь орлогын дүнг 39.8 тэрбум төгрөгөөр баталсан. Үүнтэй уялдуулан аймгийн 2021–2024 оны төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн динамик шинжилгээ, татварын нэр төрөл бүрээр хийсэн судалгаа, тооцооллыг үндэслэн орлогын боломжит дүнг нэмэгдүүлж төсвийн төслийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн IX хуралдаанаар батлуулсан.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
	өргөн мэдүүлж хэлэлцүүлэн батлуулах						
9.4	Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг хянаж, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Байгууллагын төсөв	Орлогын гүйцэтгэл /сая төг /	523.5	575.8	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, хяналтын ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/279 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Санхүү, төрийн сангийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын газар хамтарсан удирдамжаар ажлын хэсэг байгуулан Шинэжинст, Бөмбөгөр, Баян-овоо, Галуут суманд үйл ажиллагаа явуулж буй томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, мэдээллийг тулгаж, бүртгэлгүй үл хөдлөх хөрөнгийг бүртгэж татварт хамруулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хяналт шалгалт, зөвлөн туслах ажил зохион байгуулсан. Улсын бүртгэлийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, судалгаа мэдээллийг татварын баазтай тулган мэдээллийн зөрүүг арилгах ажлыг зохион байгуулж, сумдын татварын байцаагч, улсын бүртгэгч нартай хамтран 19 сумын үл хөдлөх эд хөрөнгийн судалгаа мэдээллийг тулган баталгаажуулсан. Эдгээр ажлын үр дүнд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын гүйцэтгэл 2024 онд 0.7 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байсан бол 2025 онд 2.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн 3.7 дахин өсгөсөн амжилттай байна.	100
9.5	Санхүүгийн албаны дарга нарт "Хөгжлийн зорилт, төсвийн уялдааг хангасан үр дүнд суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулна.	Байгууллагын төсөв	Сургалтын тоо	0	20	Сумын санхүүгийн алба, төсөвт байгууллагуудад "Хөгжлийн зорилт, төсвийн уялдааг хангасан үр дүнд суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж ажиллахаар төлөвлөсөн боловч 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 8/45 дугаар тогтоолоор жилийн хөгжлийн төлөвлөгөөнөөс хасагдсан.	0

1	2	3	4	5	6	7	8
9.6	Сумдын санхүүгийн албаны үйл ажиллагааг сайжруулах "Update work" аяныг зохион байгуулах	Хөтөлбөр 3.0	Сургалтын тоо Хамрагдсан албан хаагчийн тоо	0 0	1 40	Аймгийн Засаг даргын 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн а/263 захирамж, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 36 дугаар удирдамжаар UPDATE WORK-2025 уралдааны удирдамж, төлөвлөгөөг батлуулж, сумдын санхүүгийн албаны дунд 2025 оны 5 дугаар сарын 5-ний өдрөөс эхлэн зарласан.. Уралдаанд оролцогч 20 сумын санхүүгийн албаны 40 албан хаагч хамрагдсанаас Гурванбулаг, Бууцагаан, Өлзийт сумын санхүүгийн алба эхний байр, Тусгай байр Баянцагаан, Шинэжинст, Баянбулаг, Баянговь сумууд эзэллээ.	100
9.7	Төрийн сангийн удирдлагын цахим системийн хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх	Хөтөлбөр 3.0	Систем хөгжүүлэлтийн хувь	90	95	Төрийн санд төсөвт байгууллагуудын харилцах данс нээх, хаах, санхүүжилт, орлогын хаалт, залруулгын бичилт, нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийн хүсэлтийг байгууллагууд албан бичиг, холбогдох баримтын хамт цаасаар ирүүлж шийдвэрлүүлдэг байсан бол 2025 онд Төрийн сангийн удирдлагын цахим системд дээрх 3 хөгжүүлэлтийг амжилттай хийж, 20 сум, 190 төсөвт байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Энэ нь цаг хугацаа, цаас, ажлын түргэн шуурхай явагдах маш чухал ажил болж чадсан.	100
<b>Зорилт-10. Нийгмийн салбарын чанар хүртээмжийг сайжруулах</b>							
10.1	"Хонгорын хүүхэд" хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангахад хяналт тавих	Жилийн хөгжлийн төлөвлөгөө 30.00 сая төгрөг	Гүйцэтгэлийн хувь	0	100	"Хонгорын хүүхэд" хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/145 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг "Хонгорын хүүхэд хөтөлбөр"-ийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 7/12 дугаар тогтоолоор батлуулсан. "Хонгорын хүүхэд" хөтөлбөрийг танилцуулах сургалтыг 5 удаа зохион байгуулж 8 ерөнхий боловсролын сургуулийн 600 гаруй сурагч, 32 багш нар хамрагдаж хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй болсон. Аймгийн хүүхдийн зөвлөлийн гишүүдтэй хамтран тус хөтөлбөрийг иргэд олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор контент хийж цахим хуудсаар дамжуулан 8500 хүнд мэдээллийг хүргэж ажилласан. Аймгийн хэмжээнд 18 удаагийн нөлөөллийн ажил, сургалтаар 16890 хүүхдэд хүрч ажилласан байна.	100

1	2	3	4	5	6	7	8
10.2	Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалд оролцох	Жилийн хөгжлийн төлөвлөгөө 30.0 сая төгрөг	Гүйцэтгэлийн хувь	0	100	"Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль" наадамд аймаг орон нутгаа төлөөлж удирдлага зохион байгуулалтаар 13 албан хаагч, соёлын биет бус өвийн 7 ай сав төрөл зүйлийн хүрээнд 32 өвлөн уламжлагч, суралцагч хүүхдүүдийг хамруулж, нийт 40 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. "Монгол наадмын уламжлалыг өөрийн орон нутгийн өв соёл, онцлог хэв шинжээр хамруулж наадамчин олонд таниулан сурталчилсан. Орон нутгийн төсвөөс 20.0 сая, Соёл, урлагийн газраас 30.0 сая төгрөгийн төсөв зарцуулсан. "Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль" наадамд Байгалийн сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйлийн төрөлд Баян-Овоо сумын харьяат өвлөн уламжлагч Г.Сономбал шалгарч 1.0 сая төгрөг, Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага төрөлд шилдэг өвлөн суралцагч хүүхдээр Өлзийт сумын харьяат морь цоллооч хүү Т.Тэмүүлэн нар шалгарч, 500.0 мянган төгрөгөөр тус тус шагнуулсан.	100
10.3	"Эрүүл мэндийг дэмжих жил"-ийн арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Гүйцэтгэлийн хувь	0	100	Эрүүл мэндийг дэмжих жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхжуулан сургах 3 чиглэлээр 79 заалттайгаар боловсруулж, аймгийн Засаг даргын 2025 оны А/01 дугаартай захирамжаар батлан, 20 сум, төрийн бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, хэрэгжилтийг 94 хувийн гүйцэтгэлтэй ханган ажилласан. Нэрлэсэн жилийн онцлог ажлаас дурдвал: 1.Нэгдсэн эмнэлгийн Улсын жишиг амбулаторийг шинээр ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. 2.БНСУ-ын Хьондай эмнэлэгтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, 60 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулан сургаж, туршлага судалсан. 3. "Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төвлөрлийг сааруулах төсөл"-г 1 жилийн хугацаатайгаар эхлүүлж, ГССҮТ-н эмч нарын 4 баг ирж ажилласан бөгөөд одоогоор нийт 1618 хүнд үзлэг, оношилгоо эмчилгээ хийж, яс үений эмгэг, мөчдийн хугарал, толгой, хүзүү, нурууны гэмтэлтэй иргэдэд мэс заслын тусламж үйлчилгээг орон нутагт нь үзүүлж, нутгаас гаралтай 2 эмч аймагт тогтмол ажиллаж, эмч мэргэжилтнүүдийг дагалдуулан	100

1	2	3	4	5	6	7	8
						сургаж, гэмтлийн тусламж үйлчилгээг иргэдэд цаг алдалгүй үзүүлж байна.	
10.4	Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний "хүрээнд "Эрүүл иргэн хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Жилийн хөгжлийн төлөвлөгөө 50.0 сая төгрөг	Гүйцэтгэлийн хувь	0	100	"Эрүүл иргэн-Хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/216 дугаар захирамжаар Эрүүл иргэн-хонгорын баялаг арга хэмжээнд зарцуулах төсвийн хуваарийг батлан, 2025 оны Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 25.0 сая төгрөгийн төсвийг 95 хувьтай зарцуулсан. Уг арга хэмжээний хүрээнд "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээн, "Өсвөр үеийн эрүүл мэнд" зорилтот арга хэмжээ, "Эрүүл хүүхэд-5" дадал эзэмшүүлэх төсөлт арга хэмжээ, "Алтан 1000 хоног", "Эрүүл чийрэг эр хүн" аян, "Эрүүл мэндийн салбарын эмчилгээний хоолны тогооч нарыг чадавхжуулах" сургалт зэрэг 6 зорилтот арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.	90
10.5	Нийгмийн салбарын тэргүүлэх чиглэлийн зорилтыг хангах төсөл хөтөлбөрийг боловсруулж, олон улсын төсөл хөтөлбөрийн болон бусад байгууллагатай хамтрах	-	Боловсруулсан төсөл хөтөлбөрийн тоо	0	6	Өвсний үндэс хөтөлбөрт Уламжлалт, сэргээн засах төвийн засвар үйлчилгээ, Эрчимт эмчилгээний тасгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, Өлзийт сумын сургуулийн барилгын гадна засварын хийх чиглэлээр 3 төсөл бичиж, албан бичгээр хүргүүлсэн. Японы Хүүхдийг ивээх санд сургуульд суурилсан хүүхэд хамгаалал, бэлгийн боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг хүргүүлсэн. Нийт нийгмийн салбарын 6 төсөл боловсруулж Улсын Их Хурлын гишүүд, олон улсын байгууллагуудад хүргүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	70
10.6	"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх /2023-2026 он / арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн зардал 2.5 сая төгрөг	Хэрэгжилтийн хувь	70	80	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 зорилго, 16 зорилт, 39 арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлэн 70,8 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн байна. "Жендэрийн мэдрэмжтэй төрийн байгууллага шалгаруулах уралдаан"-д 2024 онд төрийн 4 байгууллага оролцож байсан бол энэ жилийн уралдаанд төрийн 16 байгууллага оролцсоноос 2 сумын 3 байгууллага оролцсон нь төрийн байгууллагууд Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг бий болгоход тодорхой ахиц гарч байгаагийн илэрхийлэл юм. Уралдаанд ирүүлсэн тайланг удирдамжид заасны дагуу Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын 34 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж нийлбэр дүнгээр Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 139 оноогоор "Тэргүүн	8

1	2	3	4	5	6	7	8
						байр", Политехникийн коллеж 134 оноогоор "Дэд байр", аймгийн Татварын газар 123 оноогоор "Гутгаар байр", Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар 121 оноогоор "Тусгай байр"-т шалгарсныг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.	
10.7	Бага насны хүүхэд цогц хөгжил арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн зардал 3.0 сая төгрөг	Хэрэгжилтийн хувь	90	95	Бага насны хүүхэд цогц хөгжил арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай байна. Төлөвлөгөөний хүрээнд 2025 онд "Сургуулийн өмнөх боловсролын өнөөгийн чиг хандлага" сэдэвт сургалт, туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулж, 32 цэцэрлэгийн 77 багш хамруулан, сургагч багшаар бэлтгэсэн.	100
10.8	"Хонгорын гэр бүл" арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн зардал 3.0 сая төгрөг	Хэрэгжилтийн хувь	93	95	"Хонгорын гэр бүл" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилт 95 хувьтай, хөтөлбөрийн хүрээнд "Гэр бүлийн боловсрол олгох" 6 удаагийн сургалтад Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн 81 албан хаагч хамрагдсан. 25 цагийн бүжгийн хичээлийг шинэ татагдсан цэргүүдэд зааж урлагаар дамжуулан эрчүүдийн, ирээдүйн аав нарын боловсролыг дэмжин ажиллалаа. "Сайн аав" зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэн хөвгүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих олон талт үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор сэтгэл зүйчдийн нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 11 сарын 20-ны өдөр Номундалай цогцолбор сургууль дээр, 2025 оны 11 сарын 27-ны өдөр Баруун бүс худалдааны төв дээр, 2025 оны 12 сарын 05-ны өдөр дунд зах худалдааны төв дээр тус тус зохион байгуулан 2416 өсвөр насны хөвгүүд, 687 эрчүүдэд хүрч ажиллалаа.	100
10.9	"Хүүхдэд ээлтэй орон хөтөлбөрийг нутаг" хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн зардал 3.0 сая төгрөг	Хэрэгжилтийн хувь	90	95	Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. "Судлаач хүүхэд клуб"-ийн сурагчдыг чадавхжуулах "Карл поппер"-ийн мэтгэлцээнийг 12 багийн 36 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Мэтгэлцээний тэмцээнд судлаач хүүхэд клубийн гишүүн сурагчид бүгд оролцож, чадавхжсан. Хүүхдийн амьдралын бүхий л талбарт хүүхдийн оролцоог тодорхойлох, хүүхдийн төлөө хийж байгаа ажлуудыг хүүхдийн нүдээр харж, үнэлэх, тэдний тулгамдсан асуудлыг бодлого шийдвэрт тусгах, хүүхдэд нөлөөлөх аливаа асуудлаар бодлого	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог хангах зорилгоор "Хүүхэд-Хайр-Ирээдүй" уриатай "Монголын Хүүхдийн зөвлөлийн 2025 оны үндэсний майхант цугларалт"-д хүүхдийн зөвлөлийн төлөөлөл 8 хүүхэд, 1 мэргэжилтэн, байгууллагын жолоочийн хамт оролцсон. Майхант цуглаларалтад оролцсоноор хүүхдийн хөгжлийг дэмжиж, манлайлагч хүүхдүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, тогтвортой хөгжилд хүүхдийн дуу хоолойг илүү тодорхой хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.</p>	
<b>Зорилт- 11. Хөрөнгө оруулалтын чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлын хяналтыг сайжруулах</b>							
11.1	Иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах	-	Газар өмчилсөн иргэний тоо	12625	13000	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 3/19 дүгээр тогтоолоор аймгийн хэмжээнд 2025 онд 716 иргэнд газар өмчлүүлэхээр газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоон батлуулж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар тус тогтоолыг хэлэлцэн 574 иргэнд газар өмчлүүлэхээр Засгийн газрын 2025 оны 119 дүгээр тогтоол батлагдсан боловч 140 иргэний газар үерийн даланд төлөвлөгдсөн тул олгох боломжгүй болсон. Дээрх тогтоолын дагуу тайлант онд нийт 434 иргэнд газрыг өмчлүүлсэн. Ингэснээр 13059 иргэн газар өмчлөх эрхээ баталгаажуулсан байна.</p>	100
11.2	Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	-	Гэрээний хэрэгжилтийн хувь	90	95	<p>Өнгөрсөн онд гэрээ байгуулсан "Ай Эн Ди" ХХК, "Вояжер минерал ресурсес" ХХК, "Одод гоулд" ХХК, "Монголболгаргео" ХХК, "Эрдэнэ Монгол" ХХК зэрэг 6 тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг 96 хувьтай дүгнэсэн. Энэ онд 13 аж ахуйн нэгжтэй 1,407.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар захирамжаар "Эрдэнэ Монгол" ХХК, "Наранмандал Энтерпрайзес" ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулсан. Мөн аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/383 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 13 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн</p>	100

1	2	3	4	5	6	7	8
11.3	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагаа, санхүүжилт, барилга угсралтын үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр сумдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	-	Сумын тоо	0	20	Сумдын удирдлага, холбогдох албан тушаалтнуудыг хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиглэлээр чадавхжуулах сургалтыг орон нутгийн хөгжлийн төв Баянхонгор, Богд, Баянцагаан, Бууцагаан, Жаргалант сумдад 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд бүсчлэн 20 сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудад зохион байгуулсан. аймаг, сумдын төсөв батлах тогтоолын 1 дүгээр хавсралтаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийг батлуулахад анхаар чиглэл өгч ажиллаж байна.	100
11.4	Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламжид хяналт тавих	Техник хяналтын зардал	Хяналтын тоо	24	36	Улсын төсвийн 117 тэрбум төгрөгийн 23 төсөл, арга хэмжээ орон нутгийн төсвийн 8.2 тэрбум төгрөгийн 45 төсөл, арга хэмжээ, хувийн хөрөнгө оруулалттай 40 барилга байгууламж, нийт 109 барилга байгууламжид барилгын захиалагчийн хяналтыг тавьсан.	100
11.5	Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас Нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэлх авто замын ажлыг хийж гүйцэтгэх	Замын сан 2.049.0	Замын урт км	0	1.3	Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэлх авто замын далан ухмалын ажил, буталсан чулуун суурь байгуулах, авто замын хашлага байрлуулах, замын хучилт, тэмдэглэгээ болон тоноглолын ажил бүрэн хийгдэж дууссан. Авто замын зорчих хэсгийг нээсэн, одоогийн байдлаар ашиглалтын байдал хэвийн. Ажлын гүйцэтгэлд 906.2 сая төгрөг зарцуулагдсан.	100
11.6	Сумдын малчид, төлчдийн зөвлөгөөн зохион байгуулах	-	Сумын тоо	0	20	Аймгийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар сумдын малчид, төлчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж, улс, аймгаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар танилцуулах зорилгоор аймгийн удирдлагууд оролцох ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/25 дугаар захирамжаар томилон ажилласан. Сумдын малчид төлчдийн зөвлөгөөн хуваарийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 24-нөөс 02 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулагдан 4 ажлын хэсэг 4 чиглэлд ажилласан. Аймгийн хэмжээнд нийт 20 сумын 4188 малчид, төлчид	100

1	2	3	4	5	6	7	8
						зөвлөгөөнд оролцсон ба төр засгаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар танилцуулан мэдээлэл, арга зүйн зөвлөмж өгч, хөдөө аж ахуйн салбарын шилдгүүдээ шалгаруулан шагнаж урамшуулж ажилласан.	
11.7	Стратегийн хүнсний нөөцийг бүрдүүлж ажиллах	ХТХАХЗ 50.0	Нөөц бүрдүүлэлт / тн/	180	200	Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх ажлыг "Баян Өсөх Агро" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт эрх шилжүүлэн гүйцэтгүүлж, овъёос, вандуй, сонгино, төмс, манжин, хүрэн манжин зэрэг хүнсний ногооны 50тн үрийг тариалж 400тн ургац хураан авч нөөц бүрдүүлсэн байна. Хаврын улиралд мах бэлтгэдэг орон нутгийн 3 ААН үйлдвэрийн аргаар 110тн, уламжлалт аргаар 172тн нөөцийн мах бэлтгэн зах зээлд хэрэглэгчдэд нийлүүлсэн. Стратегийн хүнсний хомсдол хаврын улиралд үүсээгүй.	100
11.8	"Цагаан алт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн зардал 3.0 сая төгрөг	Хэрэгжилтийн хувь	0	50	Цагаан алт үндэсний хөдөлгөөнийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 3 удаагийн сургалт уулзалтыг зохион байгуулан, 137 иргэн, ААН-ийг хамруулж, 20 сумдаас хөнгөн үйлдвэрлэл эрхлэгчдийн суурь судалгааг гаргаж, нэгтгэсэн. Хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 6 аж ахуй нэгжийн нэрсийг мэргэжлийн холбоодод уламжлан, ХХААХҮСайдын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 02/1449 албан тоотоор нэрсийг батлуулж арилжааны банканд хүргүүлэн, зээлийг судлуулж "Креатив ливон" ХХК арьсан эдлэл үйлдвэрлэлээр 160.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан.	100
<b>Зорилт-12. Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангах</b>							
12.1	Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд Цэрэг спортын "Дөл-2025" цогцолбор тэмцээнийг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 20.0 сая төгрөг	Баг, тамирчдын гаргасан амжилтын хувь	12	16	Аймгийн Засаг даргын нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг спортын Дөл-2025 тэмцээн 5 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Цогцолбор тэмцээнд Номгон сургууль, Эрдэм сургууль, Соого-Сейкео, Номундалай, 5 дугаар сургууль, Эрдэнэмандал, Баянлиг, Жаргалант сумын ахлах ангийн 10 сургуулийн 10 баг тамирчид өрсөлдлөө. Тэмцээнийг жагсаалын үзүүлэх тоглолт, гэрийн даалгавар, маршийн тэмцээнээр зохион байгуулан явуулсан. Тэмцээний тэргүүн байруудад шалгарсан баг тамирчдаас сонгон шалгаруулж Улсын аварга шалгаруулах тэмцээнд сурагчдыг бэлтгэн оролцуулж VI байр эзэлсэн амжилт үзүүлсэн.	100
12.2	Цэргийн бүртгэлийг хөтөлх, зохион байгуулах	Байгууллагын төсөв	Цэргийн бүртгэд	90	95	Аймгийн 2025 оны "Цэргийн бүртгэл"-ийг цахим болон цаасан хэлбэрээр хослуулан 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 17-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгууллаа. Цэргийн	100

1	2	3	4	5	6	7	8
			бүртгүүлсэн иргэдийн хувь			бүртгэл аймгийн хэмжээнд 96 хувьтай явагдлаа. Цэргийн бүртгэлийн талаарх мэдээлэл зар, сурталчилгааг иргэд, олон нийтэд дараах байдлаар хүргэсэн. Цэргийн бүртгэл зохион байгуулж явуулах нэгдсэн семинарыг 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр цахим хэлбэрээр 20 сумын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг даалгавар өгч ажилласан. Цэргийн бүртгэл зохион байгуулахад ашиглагдах зар сурталчилгааны зурагт хуудас, тараах материал 1200 ширхгийг хэвлүүлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүлээлгэн өгсөн. Мөн Нээлттэй Засаг-Нэг Баянхонгор, Bayankhongorlive.mn сайтууд болон Номгон, Баянхонгор телевизүүдээр мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулсан.	
12.3	Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах	Байгуулагын төсөв	Хяналтын тоо	100	100	“Баянхонгор аймгийн нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны халалт, татлагын ажлыг зохион байгуулах тухай” 2025 оны А/193 дугаар захирамжийн дагуу цэрэг татлагыг 04 дүгээр сарын 16-26 өдрүүдэд, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 2025 оны А/511 дүгээр захирамжийн дагуу цэрэг татах ажлыг 10 дугаар сарын 01-14-ний өдрүүдэд аймгийн 20 сумдад зохион байгуулсан. Зэвсэгт хүчний Жанжин штабын тоон даалгаврын дагуу нэгдүгээр ээлжээр Хилийн цэрэгт 100 хувь, Дотоодын цэрэгт 120 хувь, хоёрдугаар ээлжээр Зэвсэгт хүчний ангиудад 101.2 хувь, Дотоодын цэрэгт 85 хувиар тус тус биелүүлсэн байна. Ээлжит татлагуудаар Баянхонгор телевиз, Хонгор ТВ, Нээлттэй Засаг нэг Баянхонгор зэрэг сайтуудтай гэрээ байгуулан 2 контент, хулдаасан хэвлэл, бэлтгэн олон нийтийн хэвлэл мэдээлэл, сум орон нутгийн цахим хаягуудаар байршуулан хамтарч ажилласан нь цэрэг татлагын хяналтын тоо биелэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Аймгийн цэрэг татлагын товчоо 27,010,600 төгрөгийг батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, видео контент бэлтгэх, тэмцээн уралдаан соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулахад тус тус зарцуулсан.	100
12.4	Мөнгөн төлбөр төлөх иргэдийн нэрийн бүртгэл гаргаж, төрийн санд иргэдийн мөнгөн		Мөнгөн төлбөр төлөх иргэдийн тоо	312	320	Монгол Улсын Засгийн газрын “Мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 2025 оны 141 дүгээр тогтоолын дагуу энэ оны жилийн эцсийн байдлаар цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан 71 иргэн цэргийн	100

1	2	3	4	5	6	7	8
	төлбөрийг төвлөрүүлэх					дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр төлж Төрийн санд 148,533,483 төгрөгийг төвлөрүүлээд байна.	
12.5	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу бүсийн томилгоот нэгжүүдтэй үзүүлэх сургалт зохион байгуулах	Орон нутгийн төсөв 20.0 сая төгрөг	-Сургалтын тоо, Хамрагдсан иргэдийн тоо	1 178	2 200	Аймгийн Засаг даргын 2025 оны А/576 дугаар захирамжийг удирдлага болгон Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн "Удирдах бүрэлдэхүүний" сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын нутагт зохион байгуулсан. Сургалтад Баянхонгор аймгийн, Өлзийт, Бөмбөгөр, Хүрээмарал, Бууцагаан, Галуут, Гурванбулаг, Заг, Баянбулаг сумдын Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний 60 бэлтгэл үүрэгтэн хамрагдаж, сургалтад автомашин 4 нэгж, тусгай зориулалтын 1 нэгж, мотоцикл 8 нэгж, ангийн буу 5 ширхгийг тус тус дайчлан татаж, хамруулсан. Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулахад дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс 4,728,000 (дөрвөн сая долоон зуун хорин найман мянга) төгрөгийг төсөвлөж зарцуулсан.	100
12.6	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийг байгалийн болзошгүй эрсдэлээс хамгаалах гамшиг ослын үед үүрэг гүйцэтгүүлэх, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах.	Орон нутгийн төсөв 20.0 сая төгрөг	Гүйцэтгэсэн ажлын тоо	3	4	Цэргийн дүйцүүлэх албаны "Бэлтгэл шат"-ны сургалтыг 05 дугаар сарын 24-ний өдрөөс 06 дугаар сарын 02-ы өдрүүдэд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хээрийн байрлалд тус тус зохион байгуулан явуулсан. Сургалтад 2025-2027 онд алба хаах 50 иргэн хамрагдаж цэргийн дүйцүүлэх алба хаах гэрээ байгуулан хамрагдсан. "Тусгай үүргийн бэлтгэл шатны" сургалтыг хээрийн байрлалд 2025 оны 08 дугаар сарын 10-наас 08 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулан явууллаа. Сургалтад 2024-2026 онд цэргийн дүйцүүлэх албыг хаах нийт 20 сумын 48 иргэн бүрэн хамрагдсан.	100
<b>Зорилт -13. Байгууллагын өдөр тутмын алба үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулахад бэлэн байдал, удирдлага арга зүйгээр хангах</b>							
13.1	Байгууллагын үүдний хэсгийг засварлаж тохижуулах	Байгууллагын төсөв	Ажлын гүйцэтгэлийн хувь	50	100	Байгууллагын утгах үйлчилгээний хэсэгт 5.0 сая төгрөгөөр бүрэн засвар хийж байршлыг өөрчлөн тохижуулахаас гадна иргэдэд зориулсан хүлээлгийн буйдан сэтгүүлийн ширээг байршуулан тухтай цэвэр орчинг бүрдүүлсэн.	100
13.2	Хурлын зааланд их засвар хийх	Байгууллагын төсөв	Ажлын гүйцэтгэлийн хувь	40	100	Засаг даргын Тамгын газар 205 номерыг хурлын танхимаар тохижуулсан. Том хурлын зааланд 2,280,000 төгрөгөөр динамик яригч-2 ширхэг, мульт кабель-1 ширхэг, микны станц-4 ширхэг, 4 гартай зайны мик-1 ширхэг, авкус залгуур-2	100

1	2	3	4	5	6	7	8
						ширхгийг авч хурлын үйл ажиллагаа хэвийн явагдах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.	
13.3	Байгууллагын цэвэр, бохир усны шугам сүлжээний их засвар хийх	Байгууллагын төсөв	Ажлын гүйцэтгэлийн хувь	40	100	Байгууллагын цэвэр, бохир усны шугам сүлжээний их засвар нь хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд санхүүжилт тавигдаагүй учир хийгдээгүй.	0
<b>Хэрэгжилтийн дундаж</b>						<b>90.4</b>	

ТАНИЛЦСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Э.ЭНХБАТ

ХЯНАСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

П.ОТГОНБАЯР

НЭГТГЭСЭН:  
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БУЛГАМАА